Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ О.ЖАРГАЛЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх”** | | | | | | | |
| 1. | *Арга хэмжээ 1.1.* Монгол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | Монгол Улсын Их хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолооор батлагдсан “Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний 1 дүгээр улирлын хэрэгжилтийн тайланг ТЗУГ-аас хүлээн авч, хяналт-шинжилгээ үнэлгээг 3 хавсралт тус бүрээр (Бодлогын тэргүүлэх чиглэл, оны төлөвлөгөө, төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт) хийсэн. Үүнд:<br>1-р хавсралт “Монгол улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”,<br>2-р хавсралт “Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”,<br>3-р хавсралт “Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт” | 03<br>06 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний 2025 оны 1 дүгээр улирлын хэрэгжилт нь “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн. Уг үнэлгээний зөвлөмж, дүгнэлтийг ГБХНХ-ын сайд, ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, холбогдох газар нэгжийн дарга нарт хүргүүлэн танилцуулсан.<br>Тус бодлогын баримт бичгийн 2025 оны 2 дугаар улирал буюу эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг Төрийн захиргааны удирдлагын газраас 2025 оны 06 дугаар сарын 13-ны дотор авч, ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, тайлан мэдээллийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний дотор Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д тайлагнаж, газрын даргаар баталгаажуулалт хийлгэхээр ажиллаж байна. | | |
| 2. | *Арга хэмжээ 1.2.* Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 100% | Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Төсвийн ерөнхийлөн захирагч (ГБХНХ-ын сайд)-ийн 2024 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЭЗСТХОГ-т хүргүүлсэн. Тус газар нь үнэлгээ бүхий тайланг Сангийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.<br><br>УИХ-ын Төсвийн зарлагын Хяналтын дэд хорооны 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн УИХ-15/4964 дүгээр албан бичгийн дагуу Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Төсвийн ерөнхийлөн захирагч (ГБХНХ-ын сайд)-ийн 2024 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтийн тайланг (хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн) ГБХНХ-ын сайдын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/1621 дүгээр албан бичгээр болон цахимаар хүргүүлэн ажиллалаа. | 03<br>05 | |
| 3. | *Арга хэмжээ 1.3.* Монгол улсын | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан дах Монгол улсын Ерөнхий сайдын шуурхай үүрэг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайланг үнэлгээний цахим системд оруулж, баталгаажуулна. | | | | даалгавар цэсэнд мэдээлсэн нийт 3 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг холбогдох газруудаас авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ХШҮДАГ-ын даргад танилцуулан 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр цахимд баталгаажуулсан. | 01<br>06 | |
| 4. | *Арга хэмжээ 1.4.* Төсвийн ерөнхийлөн захирагчийн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 100% | Монгол улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Говьсүмбэр аймгуудын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгуудын нэгтгэлд 2025 оны 01 дүгээр сард хүргүүлэн ажилласан. | 01<br>01 | |
| 5. | *Арга хэмжээ 1.5.* Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | **Нэг.** ГБХНХ-ын сайдын 2024 оны тушаалын хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд:<br>Нийт А тушаал-200, Б тушаал-30, Албан даалгавар-2 тус тус байсан.<br>1. А тушаалын биелэлт – 91.9 хувийн үнэлгээтэй буюу “бүрэн хэрэгжсэн”,<br>2. Б тушаалын биелэлт – 100 хувийн үнэлгээтэй буюу “бүрэн хэрэгжсэн”,<br>3. Албан даалгаврын биелэлт – 90 хувийн үнэлгээтэй буюу “бүрэн хэрэгжсэн” үнэлэгдсэн. | 01<br>06 | |
| | | | | | ГБХНХ-ын сайдын 2025 оны эхний хагас жилийн тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж дүгнэлтийг 2025 оны 07 дугаар сарын 05-ны дотор сайд, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулахаар ажиллаж байна.<br>**Хоёр.** ГБХНХ-ын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан даалгаварт туссан 9 газар, нэгжийн чиг үүрэгт хамаарах 90 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үнэлгээ хийсэн. Албан даалгаврын 2025 оны 01 дүгээр улирлын биелэлт 46.3 хувь буюу "эрчимжүүлэх шаардлагатай" үнэлэгдсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан дүгнэлт, танилцуулга зөвлөмжийг сайд, ТНБД, газар нэгжийн дарга нарт хүргүүлэн танилцуулсан. | | |
| **Зорилт 2. "Байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэл, үр дүн, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх"** | | | | | | | |
| 1. | *Арга хэмжээ 2.1.* Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ын дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох тайлан, зөвлөмжийг хүргүүлэхээр ажиллаж байна.<br><br>Тус агентлагийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт 53 арга хэмжээ туссан бөгөөд 2025 оны 01 дүгээр сард байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлтэй танилцан, зохих санал зөвлөмжийг хүргүүлсний дагуу холбогдох сайжруулалтыг хийж батлуулсан болно. | 06<br>06 | |
| 2. | *Арга хэмжээ 2.2.* Гэр бүлийн бодлогын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ын дагуу ГБХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг журамд заасан хугацаанд багтаан хийж, холбогдох тайлан, зөвлөмжийг хүргүүлэхээр ажиллаж байна.<br><br>ГББГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1-р улирлын байдлаарх хэрэгжилтэд 2025 оны 4-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд үнэлгээний дүн 21.2 хувь байсан. | 06<br>06 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Үнэлгээний зөвлөмж, дүгнэлтийг тус газрын даргын үүрэг гүйцэтгэгчид хүргүүлэн ажилласан. | | |
| 3. | *Арга хэмжээ 2.3.* Салбарын хяналтын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ын дагуу ГБХНХЯ-ны Салбарын хяналтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг журамд заасан хугацаанд багтаан хийж, холбогдох тайлан зөвлөмжийг хүргүүлэхээр ажиллаж байна.<br><br>СХГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1-р улирлын байдлаарх хэрэгжилтэд 2025 оны 4-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд үнэлгээний дүн 63.1 хувь байсан. Үнэлгээний зөвлөмж, дүгнэлтийг газрын даргад нь хүргүүлэн ажилласан. | 06<br><br>06 | |
| **Зорилт 3. "Байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт, үнэлгээ хийх"** | | | | | | | |
| 1. | *Арга хэмжээ 3.1.* Харьяа байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамж, өргөдлийн хүрээнд дотоод хяналт, шалгалт хийнэ. | Хяналт, шалгалт хийсэн эсэх<br><br>/тийм-1,<br><br>үгүй-0/ | - | 1 | **1.** Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн "Дотоод аудит хийх тухай" А/18 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь ХХҮЕГ-ын 2022, 2023 он, 2024 оны эхний хагас жилийн байгууллагын болон төсөв санхүү, тусгай сангийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийж, аудитын тайланг 2025 оны 02 дугаар сард Сайдын зөвлөл, Дотоод аудитын хороонд танилцуулан ажилласан.<br><br>Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, ХХҮЕГ-ын Төрийн захиргаа, санхүү, удирдлагын газрын хууль тогтоомжоор хэрэгжүүлэх чиг үүргийн төлөвлөлт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолт боловсруулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилт, дүгнэсэн байдал болон | 01<br><br>02 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удирдамжид заасан бусад асуудлуудад шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.<br><br>**2.** Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын цахим хуудас (cfga.gov.mn)-ны мэдээлэлд хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу 2025 оны 01 дүгээр сард хийсэн. Үүнд:<br>**Нэг.** Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт – 74.0 хувь,<br>**Хоёр.** Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал –71.7 хувь,<br>**Гурав.** Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал –60.0 хувь<br>**Дөрөв.** Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал – Үнэлэх боломжгүй буюу хамааралгүй.<br>**Тав.** Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 67.5 хувь тус тус хэрэгжсэн бөгөөд нийт **67.7** хувийн үнэлгээтэйгээр дүгнэгдсэн. | | |
| **Зорилт 4. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"** | | | | | | | |
| 1. | *Арга хэмжээ 4.1.* Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох хууль, журмын дагуу боловсруулсан байх. /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Албан тушаал (Гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээ)-ын тодорхойлолтод заасан гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам" болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан аргачлал, загварын дагуу боловсруулан ХШҮДАГ-ын даргаар хянуулж батлуулсан. | 01<br><br>01 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | | | | Төлөвлөгөөнд 5 зорилт 15 арга хэмжээ туссан бөгөөд 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг тайлагнах ажил холбогдох журмын дагуу хийгдсэн. | | |
| | | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг холбогдох журмын дагуу хугацаанд нь тайлагнасан байх. /тийм-1, үгүй-0/ | - | 1 | 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан аргачлал, загварын дагуу боловсруулан тайлагнаж, хугацаанд нь үнэлгээнд хүргүүлэн ажиллалаа. | 06<br>06 | |
| | | Баримт, тоо, мэдээллийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн байх. /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Албан бичиг, мэдээлэл хүргүүлсэн:<br>1. *<u>Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн нэгжид:</u>* ХШҮДАГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Тайлан мэдээлэл ирүүлэх тухай” 09/196 дугаар албан бичиг,<br>2. *<u>Сангийн сайдад:</u>* ГБХНХ-ын сайдын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Тайлан хүргүүлэх тухай” 01/677 дугаар албан бичиг,<br>3. *<u>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргад:</u>* ГБХНХ-ын сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолыг яаралтай хэрэгжүүлэх тухай” 01/961 дүгээр албан бичиг,<br>4. *<u>УИХ-ын Төсвийн зарлагын Хяналтын дэд хороонд</u>*: ГБХНХ-ын сайдын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Биелэлт хүргүүлэх тухай” 01/1621 дүгээр албан бичиг,<br>5. *<u>Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт цахим шуудангаар</u>*: “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл арга хэмжээний жагсаалт”, | 01<br>06 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл арга хэмжээний жагсаалт" тус тус хүргүүлсэн. | | |
| 2. | *Арга хэмжээ 4.2.* Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг хүргүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Иргэд байгууллагаас ирүүлсэн дараах өргөдлийг судалж, шийдвэрлэн хуулийн хугацаанд хариуг хүргүүлэн ажиллалаа. Үүнд:<br>1. ГБХНХ-ын сайдад 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр иргэн Л.Бадамцэцэгээс ирүүлсэн өргөдөл гомдлыг судлан шалгаж, хариуг Сайдын 2025 оны 01/961 дүгээр албан бичгээр иргэнд хүргүүлсэн ба холбогдох агентлагт чиглэл хүргүүлэн иргэний гомдлыг бүрэн шийдвэрлүүлсэн. | 01<br>06 | |
| | | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь мэдүүлсэн байх. /тийм-1, үгүй-0/ | - | 1 | 2025 оны жилийн эцсийн байдлаарх Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь (2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр) Авлигатай тэмцэх газрын холбогдох цахим системд оруулан мэдүүлж, баталгаажуулсан. | 01<br>02 | |
| 3. | *Арга хэмжээ 4.3.* Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх | Үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байх. /тийм-1, үгүй-0/ | - | 1 | ГБХНХЯ-ны удирдлага болон газрын даргын өгсөн нийт 6 үүрэг даалгаврыг цаг тухайд нь бүрэн биелүүлж ажилласан.<br>Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт (доор бичигдсэн) хэсэгт тайланг дэлгэрэнгүй тусгасан болно. | 01<br>06 | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.* Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ЭЗХЯ-нд цахимаар хүргүүлэх | Холбогдох тайланг бэлтгэн цахимаар хүргүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т туссан Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан танилцуулгыг 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яамны холбогдох газарт имэйлээр хүргүүлсэн. Тус яамнаас утсаар болон цахимаар ирүүлсэн хүсэлтийн дагуу тайлантай холбоотой нэмэлт тайлбар мэдээллийг бэлтгэн мөн хүргүүлсэн. | 01<br>01 | |
| 2. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.* ГБХНХ-ын сайдын 2024, 2025 оны тушаалаас хяналт тавих үүргийг ХШҮДАГ-т хариуцуулан даалгасан тушаалуудыг түүвэрлэн мэдээлэх | Хяналт тавих заалттай тушаалуудыг түүвэрлэн, шаардлагатай мэдээллийг өгсөн эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Газрын даргын өгсөн үүргийн дагуу Сайдын 2024, 2025 оны тушаалуудаас ХШҮДАГ-т хяналт тавих үүргийг заасан тушаалуудыг түүвэрлэн судалж, жагсаалт үүсгэн мэдээллийг имэйлээр хүргүүлсэн. Үүнд:<br>1. 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 16 тушаал,<br>2. 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 15 тушаалыг жагсаалтад оруулан тус тус мэдээлсэн. | 03<br>04 | |
| 3. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.* ГБХНХ-ын салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн төслүүдийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний | Төслүүдийн нэгтгэл тайлан танилцуулгыг Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн "Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан ирүүлэх тухай" 01/299 дүгээр албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Үүнд: ГБХНХ-ыг салбарт гадаадын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй дараах 3 төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайлан, танилцуулгыг бэлтгэн ГБХНХ-ын сайдын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/677 дугаар албан бичгээр | 01<br>03 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгтгэлийг заасан хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлэх | | | | Сангийн яам (сайд)-нд хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг төсөл тус бүрээр жагсаавал:<br><br>1. Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2 – 96.6%,<br>2. Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл – 76.6%,<br>3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл – 73.8% | | |
| 4. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.* Холбогдох ажлын хэсгийн удирдамж, тушаалын төслийг боловсруулан батлуулах | Ажлын удирдамж, тушаалын төсөл боловсруулж, батлуулсан эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв” УТҮГ-ын бүтэц, үйл ажиллагаа, хүний нөөц, өмч хөрөнгийн асуудалтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд хяналт шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамжийн төслийг боловсруулан ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлуулсан. | 01<br><br>01 | |
| 5. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.* Холбогдох байгууллагуудтай хийх уулзалт, хэлэлцүүлэгт оролцох | Уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Газрын даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу гадны байгууллага дээр зохион байгуулагдсан дараах уулзалт, хэлэлцүүлэгт оролцож, санал солилцон ажиллалаа. Үүнд:<br><br>- Засгийн Газрын Хяналт Хэрэгжүүлэх газраас 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар зочид буудалд зохион байгуулсан “Төрийн байгууллагад эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх нь” хэлэлцүүлэгт оролцож, баримт бичгийн төсөлд тусгах санал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд тулгамдаж буй асуудлын хүрээнд санал солилцож ажилласан.<br>- Улсын Их хурлын Тамгын газар Европын Холбоотой хамтран 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан “Үр дүнд суурилсан үнэлгээ, мониторингийн тогтолцоо бүрдүүлэх нь” сэдэвт салбар дундын мэргэжилтнүүдийн хэлэлцүүлэгт оролцсон. | 02<br><br>05 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6.* Холбогдох ажлын хэсэгт ажиллах | Ажлын хэсэгт ажиллаж, ажлын тайлан мэдээлэл боловсруулж өгсөн эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/64 дүгээр тушаалаар батлагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, ажлын удирдамжийн хүрээнд “Монголын СОС хүүхдийн хотхоны нийгэмлэг” ТББ-ын санхүүжилтийг (2024 оны 07 дугаар сард Монголын СОС-ын хүүхдийн хотхонд хийгдсэн аудитын шалгалтын дүгнэлтээр хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан нөхцөл илэрсэнтэй холбоотой) зогсоосон тухай мэдэгдэлтэй холбоотой тухайн байгууллагын асрамж халамжид байгаа 139 хүүхдийн эрхийн асуудал хөндөгдөж буй эсэхэд хяналт шалгалтыг хийж ажилласан. Шалгалтын хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар, Монголын СОС хүүхдийн хотхоны нийгэмлэг ТББ-аас өгөгдөл, тайлбар, мэдээлэл хүлээн авах, холбогдох хууль, стандартын хэрэгжилтийг хянах ажлыг гүйцэтгэж, холбогдох тайлан дүгнэлтийг боловсруулж, 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. | 02<br>03 | |
| 7. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7.* Холбогдох хуулийн төсөлд санал өгөх | Хуулийн төсөлд санал өгсөн эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | ГБХНХЯ-гы Гэр бүлийн бодлогын газраас боловсруулан өргөн барих “Гэр бүлийг дэмжих тухай” анхдагч хуулийн төсөлд 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр холбогдох саналыг хүргүүлэн ажилласан. | 04<br>04 | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | *Арга хэмжээ 1.* Төрийн албаны Ахлах түшмэлийн | Багц сургалтад бүрэн | - | 1 | ГБХНХЯ болон Удирдлагын Академийн “Захиалгат сургалт явуулах тухай” №УА/ТАС-25 дугаар гэрээний дагуу | 02<br>06 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана. | хамрагдаж, төгссөн байх | | | Төрийн албаны сургуулиас 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хүртэл зохион байгуулсан “Ахлах түшмэлийн багц” нийт 20 кредит цагийн сургалтад бүрэн хамрагдсан. Нийт 8 хичээлийн дүнгийн голч 3.7 байна.<br><br>2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр Удирдлагын Академийн байранд дээрх багц сургалтын улсын шалгалтыг өгч сургалтын гэрчилгээг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр гардан авна. | | |
| 2. | *Арга хэмжээ 2.*<br>Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын Академи, Төрийн албаны зөвлөл, бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдана. | Суралцсан сэдэв, хугацаа | - | 1-ээс доошгүй | Дараах байгууллага, газраас зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэн ажилласан. Үүнд:<br>- Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн зохион байгуулагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” (шинэчилсэн найруулгын)-ийн танилцуулга, сургалт, Гэрчилгээний дугаар 2025/0517,<br>- Архивын Ерөнхий газраас 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлт”-ийн чадавхижуулах сургалт,<br>- Quizmaster зөвлөх үйлчилгээний компани 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зөвлөх Б.Дөлгөөн, Монгол улсын зөвлөх багш Б.Мянган нарын “Soft skills - Хувь хүний ур чадвар” сургалт,<br>- ГБНХЯ-ны ТЗУГ-аас 2025 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборт зохион байгуулагдсан “Хүний хөгжлийн цогц хөтөлбөр” сургалт,<br>- Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Цахим сэтгүүл зүй хариуцсан дэд ерөнхийлөгч Ц.Мөнхбаатар 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдсан “Rhetoric буюу Илтгэх урлаг” сургалт, | 01<br><br>06 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Хувь хүний хөгжлийн институтийн захирал, сэтгэл зүйч М.Алтанцэцэг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулагдсан "Хувийн зохион байгуулалт ба цагийн үнэ цэнэ" сургалтад тус тус хамрагдсан. | | |
| 3. | *Арга хэмжээ 3.* Монгол бичгийн мэдлэг, чадвараа нэмэгдүүлнэ. | Мэдлэг нэмэгдсэн байх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | ГБХНХЯ, Хэлний бодлогын Үндэсний зөвлөл, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнтэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл яамны албан хаагчдад зориулан яамны байранд зохион байгуулсан Монгол бичгийн (8 удаагийн) хичээлд бүрэн хамрагдаж, монгол бичгийн унших бичих чадвараа сайжруулсан. Түүнчлэн уг сургалтаар компьютер дээр монгол бичгээр бичих анхан шатны мэдлэг, дадлага олж авсан. | 05<br>06 | |
| 4. | *Арга хэмжээ 4.* Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулах мэргэшүүлэх сургалтад хамрагдана. | Сургалтад хамрагдаж, A3 сертификат авсан байх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн зохион байгуулагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль" (шинэчилсэн найруулгын)-ийн танилцуулга, сургалтад бүрэн хамрагдсан. Улмаар ТХААГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан шалгалтад 40 онооноос 39 оноогоор тэнцэж, гэрчилгээг авсан. Гэрчилгээний дугаар 2025/0517 | 01<br>01 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ШИНЖЭЭЧ О.ЖАРГАЛ / ................................ / 2025.06.12

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

# ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ О.ЖАРГАЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

ТЖАХ-ийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудас.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

# ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ О.ЖАРГАЛЫН 2025 ОНЫ АЖЛЫН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
Нэгжийн нэр: Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Монгол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 1.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Арга хэмжээ 1.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| 4. | Арга хэмжээ 1.4. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| 5. | Арга хэмжээ 1.5. Монгол улсын Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| **Зорилт 2. ”Байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэл, үр дүн, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх” ”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 2.2. Гэр бүлийн бодлогын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний | 60 | 10 | 70 | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | | | | |
| 3. | Арга хэмжээ 2.3.<br>Салбарын хяналтын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| **Зорилт 3. "Байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт, үнэлгээ хийх"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1.<br>Харьяа байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамж, өргөдлийн хүрээнд дотоод хяналт, шалгалт хийнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| **Зорилт 4. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1.<br>Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 4.2.<br>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ | 60 | 10 | 70 | 70 |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br>Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ЭЗХЯ-нд цахимаар хүргүүлэх | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.<br>ГБХНХ-ын сайдын 2024, 2025 оны тушаалаас хяналт тавих үүргийг ХШҮДАГ-т хариуцуулан даалгасан тушаалуудыг түүвэрлэн мэдээлэх | | | | |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.<br>ГБХНХ-ын салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн төслүүдийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгтгэлийг заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлэх | | | | |
| 4 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.<br>Холбогдох ажлын хэсгийн удирдамж, тушаалын төслийг боловсруулан батлуулах | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Холбогдох байгууллагуудтай хийх уулзалт, хэлэлцүүлэгт оролцох | | | | |
| 6 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. Холбогдох ажлын хэсэгт ажиллах | | | | |
| 7 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. Холбогдох хуулийн төсөлд санал өгөх | | | | |
| **Дундаж оноо:** | | | | 70 | 70 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1. Төрийн албаны Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана. | | 13 | 13 |
| 2. | Арга хэмжээ 2. Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын Академи, Төрийн албаны зөвлөл, бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдана. | | 13 | 13 |
| 3. | Арга хэмжээ 3. Монгол бичгийн мэдлэг, чадвараа нэмэгдүүлнэ. | | 13 | 13 |
| 4. | Арга хэмжээ 4. Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулах мэргэшүүлэх сургалтад хамрагдана. | | 13 | 13 |
| **Дундаж оноо:** | | | 13 | 13 |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ ( Нэгжийн даргын үнэлгээ )

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6 | 6 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | 6 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 6 | 6 |
| 4. | Хариуцлагатай байдал | 6 | 6 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 6 | 6 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 1. | Мэргэжлийн ур чадвар №1. | 6 | 6 |
| 2. | Мэргэжлийн ур чадвар №2. | 6 | 6 |
| 3. | Мэргэжлийн ур чадвар №3. | 6 | 6 |
| **Дундаж оноо:** | | 6 | 6 |

## 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ ( Хамт олны үнэлгээ )

ТЖАХ-ийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудас.

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |

7.7

### 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (*Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.*) | 70 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээний биелэлт | 13 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (*Нэгжийн даргын үнэлгээ*) | 6 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (*Хамт олны үнэлгээ*) | 7.7 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (*Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих*) | |
| Нийт оноо = Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо, Хандлага ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)-Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо+ Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 96.7. 96.7 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

ХШҮДАГ-ын дарга ........................ / Д.Ренчиндорж /
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.20 *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Шинжээч ........................ /О.Жаргал /
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.18 *(огноо)*

ТЖАХ-ийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудас.

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

.............................. .................................... В.Түвшинжаргал

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.20 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

.............................. .................................... Б.Энхтуяа

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.20 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** **Төсвийн шууд захирагч**

ATA12944 9132155 9024070603

.......................................... .................................... /Л.Мөнхзул/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.20 *(огноо)*